



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Мөнх даатгал” ХХК-ийн Нийтийн тээврээр зорчигчийн гэнэтийн ослын “Welcome” хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.


3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Мөнх даатгал” ХХК /Т.Оюунгэрэл/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Мөнх даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	“Welcome” - Нийтийн тээврээр зорчигчийн гэнэтийн ослын хүртээмжтэй даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Авто тээврийн хэрэгслийн даатгал
4.	Даатгалын зүйл	Зорчин явагчийн гэнэтийн ослын даатгалд зорчигч автотээврийн хэрэгслээр зорчих үеийн бүх төрлийн гэнэтийн осол болон ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбогдсон зорчигчийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол
5.	Даатгалын эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>• Зам тээврийн аюул осолд өртөх буюу нийтийн тээврийн хэрэгсэл нь замын хөдөлгөөнд оролцож байх үедээ онхолдох, мөргөлдөх, болон биет зүйл мөргөх, шарваж гулсаж осолдох, өндөрлөгөөс унах, живэх болон аяллын явцад учирч болзошгүй бусад эрсдэлүүд,</li> <li>• Байгалын эрсдэлүүд буюу хүчит салхи, цасан болон шороон шуурга, цочир хүйтрэлт, хүйтэн бороо, үер усны аюул, газар хөдлөлт, хөрсний нуралт, гулгалт, цөмрөлт, аянга, гал түймрээс үүдэлтэй эрсдэлүүд,</li> <li>• Дээрх байгалийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор замд яваа тээврийн хэрэгсэл, зорчин явагчдыг түр хугацаагаар суурин газарт саатуулах эрсдэл,</li> <li>• Улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэл түр саатан зогссон үед зорчигч бууж явганаар зорчиж байх үедээ элдэв осолд өртсөнөөс үүссэн эрсдэлүүд</li> </ul>
6.	Даатгалын гэрээний хугацаа	Зорчигч тасалбар худалдан авч тээврийн хэрэгсэлд суусан үеэс эхлэн аяллын замын турш үйлчлэх бөгөөд тасалбарт дурдсан эцсийн зогсоолд очоод буух хүртэл тогтоосон маршрутаар зорчсон хугацаанд хүчинтэй байна.
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	4 бүлэг, 98 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 027 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Б.Баярмагнай
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Үйл ажиллагааны газрын захирал Б.Наранбаатар, Бизнес хөгжлийн газрын захирал Ч.Мөнхдөл